



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 11 өдөр

Дугаар А/371

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын халдварыг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг зорилтот бүлгийн хөгжлийн бэрхшээлтэй, 16 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, 65-50-аас түүнээс дээш настай)-ээс бусад тохиолдолд төлбөртэйгээр (16,000 төгрөг) авч хэрэгжүүлж ажиллахыг эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дарга, эрхлэгч нарт зөвлөж өгөрсүгэй.

2. Дундговь аймгийн хэмжээнд караокены чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг хариуцлагын гэрээ байгуулсаны үндсэн дээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч халдвар хамгааллын дэглэм, цагийн хуваарьт хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

48121010